




САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/115/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--



Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	15
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Албан шаардлага.....	16
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/36

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,322,743.00</u>	<u>33,742,513.00</u>
33	АВЛАГА	00.00	13,500.00
335	Бусад авлага	00.00	13,500.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	13,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,322,743.00	33,729,013.00
354	Хангамжийн материал	27,322,743.00	33,729,013.00
35410	Бичиг хэргийн материал	5,234,485.00	8,312,785.00
35420	Аж ахуйн материал	12,592,058.00	25,416,228.00
35470	Бусад хангамжийн материал	9,496,200.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,155,659,869.00</u>	<u>1,205,463,370.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,155,659,869.00	1,205,463,370.28
392	Биет хөрөнгө	1,087,043,869.00	1,136,847,370.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,133,036,550.67	1,231,539,950.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	-266,751,836.91	-313,997,153.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	180,699,800.00	180,699,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-115,732,880.18	-130,457,173.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	241,629,569.64	236,991,379.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-177,993,151.82	-173,799,825.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,173,420.00	65,498,420.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,609,636.45	-27,768,861.09
39209	Зам, гүүрийн байгууламж	746,403.36	746,403.36
39210	Хуримтлагдсан элэгдэл	-124,400.64	-186,600.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	129,883,500.00	144,683,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-63,913,468.67	-77,102,468.67
393	Биет бус хөрөнгө	68,616,000.00	68,616,000.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.00	-250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	68,616,000.00	68,616,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,182,982,612.00</u>	<u>1,239,205,883.28</u>
413	Өглөг	00.00	121,500.00
4136	Бусад өглөг	00.00	121,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	121,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,182,982,612.00</u>	<u>1,239,084,383.28</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,182,982,612.00	1,239,084,383.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	648,743,631.82	648,743,631.82
51101	Өмч: - төрийн	648,743,631.82	648,743,631.82
512	Хуримтлагдсан үр дүн	102,577,350.99	158,679,122.27
51210	Өмнөх үеийн үр дүн	102,577,350.99	102,577,350.99
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	56,101,771.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	431,661,629.19	431,661,629.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,182,982,612.00</u>	<u>1,239,205,883.28</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	411,201,075.00	633,433,845.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,180,244.00	180,409,725.00
120	Нийтлэг татварын бус орлого	39,180,244.00	180,409,725.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,180,244.00	10,032,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	9,496,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	536,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	39,005,244.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/	0.00	109,784,900.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/	0.00	60,592,625.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	372,020,831.00	453,024,120.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,065,331.00	22,577,020.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,194,008.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,610,331.00	14,273,012.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	455,000.00	2,110,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	368,955,500.00	430,447,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	368,955,500.00	430,447,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	456,336,678.96	577,332,073.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,336,678.96	577,332,073.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	448,848,964.44	549,712,276.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,986,702.00	231,990,523.00
210101	Үндсэн цалин	233,986,702.00	209,011,890.00
210102	Нэмэгдэл	00.00	22,978,633.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,289,817.00	29,898,602.90
210201	Тэтгэврийн даатгал	19,965,534.00	20,824,594.53
210202	Тэтгэмжийн даатгал	2,334,800.00	2,319,906.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,867,840.00	1,855,925.33
210204	Ажилгүйдлийн даатгал	463,749.00	445,289.56
210205	Эрүүл мэндийн даатгал	4,657,894.00	4,452,887.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,445,974.48	17,370,220.00
210301	Гэрэл, цахилгаан	3,501,974.48	3,758,220.00
210302	Түлш, халаалт	13,944,000.00	13,612,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,106,905.00	105,099,995.00
210401	Бичиг хэрэг	5,420,070.00	5,927,780.00
210402	Тээвэр, шатахуун	19,444,930.00	29,075,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	132,600.00	343,260.00
210404	Ном, хэвлэл	2,001,000.00	47,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	99,350.00	6,322,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,048,755.00	2,324,950.00
210408	Бараа материал акталсны зардал	2,960,200.00	2,739,880.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	58,318,825.00

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,646,800.00	11,772,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	768,700.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	50,000.00	350,000.00
210604	Урсгал засвар	6,828,100.00	11,422,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,238,000.00	5,120,000.00
210702	Дотоод албан томилолт	4,238,000.00	5,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,563,718.00	18,323,092.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,630,818.00	13,002,952.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	499,552.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	486,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,000.00	235,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,562,900.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	00.00	234,988.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,571,047.96	130,137,842.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,666,545.00	30,331,444.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	690,000.00	5,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,214,502.96	94,806,398.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,487,714.52	27,619,797.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,827,300.00	18,429,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,427,300.00	16,754,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,675,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	660,414.52	9,189,997.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,414.52	9,179,929.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-45,135,603.96</u>	<u>56,101,771.28</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-45,135,603.96</u>	<u>56,101,771.28</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>372,195,831.00</u>	<u>463,056,320.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,000.00	10,032,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	175,000.00	10,032,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,000.00	10,032,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	9,496,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	536,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	372,020,831.00	453,024,120.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,065,331.00	22,577,020.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,194,008.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,610,331.00	14,273,012.00

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	455,000.00	2,110,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	368,955,500.00	430,447,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	368,955,500.00	430,447,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	362,916,281.00	428,231,320.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	362,916,281.00	428,231,320.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,428,566.48	400,611,522.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,986,702.00	231,990,523.00
210101	Үндсэн цалин	196,994,050.00	199,309,100.00
210102	Нэмэгдэл	36,992,652.00	32,681,423.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,289,817.00	29,898,602.90
210201	Тэтгэврийн даатгал	19,953,007.00	20,824,602.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,347,381.00	2,319,902.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,867,854.00	1,855,924.63
210204	Ажилгүйдлийн даатгал	463,648.00	445,287.98
210205	Эрүүл мэндийн даатгал	4,657,927.00	4,452,885.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,445,974.48	17,370,220.00
210301	Гэрэл, цахилгаан	3,501,974.48	3,758,220.00
210302	Түлш, халаалт	13,944,000.00	13,612,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,373,210.00	40,526,640.00
210401	Бичиг хэрэг	4,773,500.00	4,006,080.00
210402	Тээвэр, шатахуун	19,444,930.00	29,075,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	132,600.00	343,260.00
210404	Ном, хэвлэл	2,701,000.00	47,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	99,350.00	6,214,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,221,830.00	840,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,578,400.00	12,481,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,019,750.00	00.00
210602	Тавилга	00.00	575,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	350,000.00	350,000.00
210604	Урсгал засвар	8,208,650.00	11,556,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,238,000.00	5,120,000.00
210702	Дотоод албан томилолт	4,238,000.00	5,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,563,718.00	18,673,092.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,630,818.00	13,352,952.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	499,552.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	486,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,000.00	235,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,562,900.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	00.00	234,988.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,952,745.00	44,551,444.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,262,745.00	39,551,444.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	690,000.00	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,487,714.52	27,619,797.65

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	6,827,300.00	18,429,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,427,300.00	16,754,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,675,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	660,414.52	9,189,997.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,414.52	9,179,929.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,279,550.00	34,825,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,279,550.00	34,825,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,279,550.00	34,825,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,279,550.00	34,825,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,279,550.00	34,825,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,279,550.00	-34,825,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	580,127,631.82	214,351,930.00	-89,202,105.73	00.00	705,277,456.09
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	580,127,631.82	214,351,930.00	-89,202,105.73	00.00	705,277,456.09
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,407,223.72	00.00	-13,407,223.72
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	648,743,631.82	431,661,629.19	102,577,350.99	00.00	1,182,982,612.00
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	648,743,631.82	431,661,629.19	102,577,350.99	00.00	1,182,982,612.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн	00.00	00.00	00.00	00.00	00.00

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	648,743,631.82	431,661,629.19	102,577,350.99	00.00	1,182,982,612.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	56,101,771.28	00.00	56,101,771.28
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	648,743,631.82	431,661,629.19	158,679,122.27	00.00	1,239,084,383.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	441,447,100.00	431,299,370.35	(10,147,729.65)	97.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,447,100.00	431,299,370.35	(10,147,729.65)	97.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	422,992,300.00	412,869,570.35	(10,122,729.65)	97.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,953,300.00	231,990,523.00	(962,777.00)	99.59
210101	Үндсэн цалин	198,159,200.00	199,309,100.00	1,149,900.00	100.58
210102	Нэмэгдэл	34,794,100.00	32,681,423.00	(2,112,677.00)	93.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,382,600.00	29,898,602.90	(1,483,997.10)	95.27
210201	Тэтгэврийн даатгал	21,632,500.00	20,824,602.13	(807,897.87)	96.27
210202	Тэтгэмжийн даатгал	2,437,500.00	2,319,902.70	(117,597.30)	95.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,950,100.00	1,855,924.63	(94,175.37)	95.17
210204	Ажилгүйдлийн даатгал	487,500.00	445,287.98	(42,212.02)	91.34
210205	Эрүүл мэндийн даатгал	4,875,000.00	4,452,885.46	(422,114.54)	91.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,671,200.00	17,370,220.00	(6,300,980.00)	73.38
210301	Гэрэл, цахилгаан	4,010,000.00	3,758,220.00	(251,780.00)	93.72
210302	Түлш, халаалт	19,661,200.00	13,612,000.00	(6,049,200.00)	69.23
2104	Хангамж, бараа материалын зардал	40,673,000.00	40,526,640.00	(146,360.00)	99.64
210401	Бичиг хэрэг	4,006,100.00	4,006,080.00	(20.00)	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	391,100.00	390,260.00	(840.00)	99.79
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,360,000.00	6,214,500.00	(145,500.00)	97.71
2107	Томилолт, зочны зардал	6,285,200.00	5,120,000.00	(1,165,200.00)	81.46
210702	Дотоод албан томилолт	6,285,200.00	5,120,000.00	(1,165,200.00)	81.46

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,920,600.00	5,906,140.00	(14,460.00)	99.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00	586,000.00	(14,000.00)	97.67
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	499,552.00	(448.00)	99.91
210807	Газрын төлбөр	235,000.00	234,988.00	(12.00)	99.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,600,400.00	44,551,444.45	(48,955.55)	99.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,600,400.00	39,551,444.45	(48,955.55)	99.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,454,800.00	18,429,800.00	(25,000.00)	99.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,454,800.00	18,429,800.00	(25,000.00)	99.86
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	1,675,000.00	(25,000.00)	98.53
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	441,447,100.00	431,299,370.35	(10,147,729.65)	97.70
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	430,447,100.00	421,763,370.35	(8,683,729.65)	97.98
132001	Орон нутгийн төсвөөс	430,447,100.00	421,763,370.35	(8,683,729.65)	97.98
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,000,000.00	9,536,000.00	(1,464,000.00)	86.69
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	536,000.00	(1,464,000.00)	26.80

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,065,331.00	22,577,020.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,065,331.00	22,577,020.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,065,331.00	22,577,020.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,065,331.00	22,577,020.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,430,331.00	22,566,952.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,065,331.00	22,577,020.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,065,331.00	22,577,020.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	6,194,008.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,610,331.00	14,273,012.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	455,000.00	2,110,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

МАХАГААНЫ АЖИЛЛАГАА
ГҮНДИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
ТАЛБАР

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг Б.Наранбаатар, 2 дугаар гарын үсгийг Д.Анхтуяа нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилго: Засаг даргаас хуулиар тогтоосон бүрэн эрх, төрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад ажлын албыг удирдлага чиг үүргээр хангаж, засаг даргын цаг үеэ олсон мэргэжлийн зөвлөгөө мэдээллээр хангаж, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх, төрийн хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлж сурталчлах, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, шударга хүргэх

Чиг үүрэг: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийн хэрэгжүүлнэ. Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг доорх зорилтыг хэрэгжүүлнэ

- Засаг даргын үнэн зөв мэдээллээр хангаж шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлж, бүрэн эрхийн хугацааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулна.
- Нутгийн захиргааны зохион байгуулалтыг боловсронгуй болгож, ажлын уялдаа холбоог сайжруулж төрийн үйлчилгээг улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр хөнгөн шуурхай, шударга явуулж хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах.
- Сумын тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж, байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, ард иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 456,336.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,563.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,194.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 4,041.3 мянган төгрөг байгаа тул төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,223.3 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.



Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,322.7	33,742.5	6,419.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	13.5	13.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	27,322.7	33,729.0	6,406.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,155,659.9	1,205,463.4	49,803.5
Үндсэн хөрөнгө	1,804,035.2	1,929,025.5	124,990.2
Хуримтлагдсан элэгдэл	(648,375.4)	(723,562.1)	(75,186.7)
Нийт хөрөнгө	1,182,982.6	1,239,205.9	56,223.3
Өр төлбөр	-	121.5	121.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,182,982.6	1,239,084.4	56,101.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,182,982.6	1,239,084.4	56,101.8

Авлагын данс дансны үлдэгдэл өмнөх онд үлдэгдэлгүй байсан бол тайлант онд 13.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,729.0 мянган төгрөг болж 6,406.3 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 12,824.2 мянга, бичиг хэргийн материал 3,078.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусад хангамжийн материал 9496.2 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,929,025.5 мянган төгрөг болж 124,990.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр 104,619.4 мянга, төслөөр 2,381.5 мянган, төсвийн хөрөнгөөр 25,025.0 мянган төгрөгийн хөрөнгө авсантай холбоотой байна. Мөн 2008 оны аймгийн ИТХ-ын 102 дугаар тогтоолоор 19,619.7 тайлант онд аймгийн мянган төгрөгийн хөрөнгийг “Баянхонгор-Эрчим” ЦТХХК-д шилжүүлсэн боловч хасагдаагүй байсныг өмнөх оны аудитаар зөвлөмж өгсний дагуу данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,239,084.4 мянган төгрөг болж 56,101.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 562,428.4 мянган төгрөгөөр-тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 120,981.3 мянган төгрөгөөр бууруулж 441,447.1 мянган төгрөгөөр анх батлагдсан байна. Санал хүргүүлсэн зардлаас цалингийн зардлыг 58,051.5 мянга, ЭМНДШ-ийг 5,706.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 42,416.2 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 441,447.1 мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 430,447.1 мянга, өвсний эргэн төлөлтөөс 9,000.0 мянга, өөрийн орлогоор 2,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 430,447.1 мянган төгрөгийн санхүүжилт авч өвсний орлогоор 9,496.2 мянга, өөрийн орлогоор 536.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн, 431,299.4 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 9,179.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 431,299.4 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа бөгөөд тайлант онд цалингийн зардал 962.8 мянга, ЭМНДШ-ийн зардал 1,484.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 17,370.2 мянга, урсгал шилжүүлэг 25.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь 2021 онд нэмэлт санхүүжилтийн дансаар "Чандмань-Баянхонгор" ХК-аар дамжин усны үнийн хөнгөлөлт 3,086.0 мянга, Статистикийн хэлтсээс тооллогын зардалд 1,087.0 мянга, аймгийн ЗДТГ-аас өвс тээвэрлэлтийн зардалд 3,494.0 мянга, Байгаль орчны уур амьсгалын сангаас 9,800.0 мянга, Шүлхий өвчний урьдчилан сэргийлэх зардалд 2,700.0 мянга, онцгой комиссын хандивт 2,110.0 мянга, хамтарсан багийн зардалд 300,0 мянган төгрөг төвлөвч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Баацагаан сумын ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 99.0 хувьтай дүгнэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 456,336. мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 120,995.4 мянган төгрөгөөр буюу 26.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь тээвэр, шатахуун, үнэ төлбөргүй бараа материалын зардал / өвс, халдвар хамгааллын хэрэгсэл/ урсгал засварын зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт



Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 514,414.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 514,414.0 мянган төгрөгийн 147 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-т заасан 2 мэдээг хугацаа хоцроож байршуулсан тул цаашид Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмжийг төсөв захирагчид өгөв.

Харин 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	94	2	0
6	Нийт	27	151	147	2	2

3.9.2 ЗАСГИЙН "ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 43 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тайлант онд 441,447.1 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 431,299.4 мянган төгрөгийг зарцуулж, 10,147.7 мянган төгрөг буюу 2.3 хувийг хэмнэсэн байна.

- Албан томилолтын зардлыг 6,285.2 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 5,120.0 мянган төгрөг зарцуулж 1,165.2 мянган төгрөг хэмнэжээ.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 25,262.2 мянган төгрөгөөр, тодотголоор 23,671.2 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 17,370.2 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 7,892.0 мянган төгрөг буюу 31.2 хувь хэмнэсэн нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг хэрэгжүүлсэн байна.

- Тухайн ЗДТГ нь 2021 оны 12 дугаар сард 13,995.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр албан тасалгааны зориулалттай ширээ, сандал, буйдан, хөшиг зэрэг тавилга эд хогшил худалдан авсан байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Сумын ЗДТГ нь сумын хэмжээний ЕБС, цэцэрлэгийн хоол, үдийн цайны тендерийг зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 31,568.0 мянган төгрөгийн өвсний тооцоотой холбоотой албан шаардлага, 24,429.8 мянган төгрөгийн хөрөнгөтэй холбоотой 1, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 нийт 2 зөвлөмж хүргүүлснийг Баацагаан сумын ЗДТГ-ын даргын 2/83 тоот албан бичгээр биелэлтийг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 25,602.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 13,995.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч, зөвлөмж хүргүүлэв.

4.1 Албан шаардлага

1.1. Тухайн ЗДТГ нь 2021 оны 12 дугаар сард 13,995.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр албан тасалгааны зориулалттай ширээ, сандал, буйдан, хөшиг зэрэг тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Өглөг авлагын тооцоог татварын худалдан авалтын тайлантай тулган шалгахад "Хонгор Ойл" ХХК-аас 1,807.5 мянган төгрөг, "Батцоож хийц" ХХК-аас 9,800.0 мянган төгрөг, Хувь хүний хөгжлийн алсын хараа институт 2,500,0 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг системд шивээгүй байсныг аудитын явцад 2022 оны 02 дугаар сард нөхөн бүртгүүлэв.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэхдээ татварын нэгдсэн системд шивэгдсэн баримтын тооцоог тулган шалгаж баримтын иж бүрдлийг бүрэн эсэхэд хяналт тавьж ажиллах.

2.1 Илрүүлэлт:

Тус байгууллага нь Шилэн дансны цахим сайтад байршуулах "... гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-тэй холбоотой 2 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-дахь заалтыг зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-т заасан Гэрээ, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалттай холбоотой мэдээллийг цаг хугацаанд нь байршуулж байх.



¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянцагаан сумын ЗДТГ	1	28,102.5	0	0	0	0	1	13,995.0	2	14,107.5

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____

